



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/150


Хужирт сум

Гэрээ цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 оны хийгдэх Хог тээврийн автомашины нийлүүлэгчээр шалгарсан “Отто мир” ХХК нь “Хог тээврийн автомашин нийлүүлэх ӨВАХУСЗДТГ/202301014” дугаартай гэрээний үүргээ биелүүлээгүй тул гэрээг цуцалсугай.
2. “Хог тээврийн автомашин авах” тендерийн нийлүүлэгчийг холбогдох хуулийн дагуу дахин сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга (Б.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.
3. Гэрээ цуцалсан тухай захирамжийг “Отто мир” ХХК-д хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Мөнхбат)-д даалгасугай.
4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн “Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай” А/71 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ